

Ээлжит хичээлийн хөтөлбөр-1

Хамрах хүрээ: 7-р анги

Сэдэв: Параллель зөөлт хувиргалт

Хугацаа: 40 минут

Зорилго: Параллель зөөлт хувиргалтын шинж чанарыг мэдэж, өгөгдсөн дүрсийг параллель зөөлтөөр дараалан хувиргах



Зорилт:



- Параллель зөөлт хувиргалтаар дараалан хувиргах
- Параллель зөөлт хувиргалтыг хийхэд хадгалагдах чанаруудыг мэдэх

Агуулга:

Өмнө судалсан агуулга	Цаашид судлах агуулга
- Дүрсийг параллель зөөлт хувиргалтаар хувиргах, хувиргалтыг таних	- Параллель зөөлт хувиргалтыг бүрэн тодорхойлоход юу шаардлагатайг ойлгох, инвариант чанарыг мэдэх, асуудал шийдвэрлэх

Цагийн төлөвлөлт:

Хичээлийн бүтцийн явц	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Хичээл зохион байгуулалт - 1 минут	- Сурагчидтай мэндлэнэ - Хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэнэ.	- Багштай мэндлэнэ - Сурагчид хичээлийн бэлтгэл байдлыг хангана.
Сэргээн санах (Сэдэлжүүлэлт) - 5 минут	Алхам 1 Геогебра программ ашиглан дүрсийг параллелаар зөөж буйг харуулах	- Геогебра программаар дүрсийг хувиргахад гарч буй өөрчлөлт, шинж тэмдгүүдийг нэрлэж, ярилцах
Шинэ хичээл - 15 минут	Алхам 1 Гурвалжин шугамыг анхны байрлалаас нь шулуунаар 2см зайд зөөжээ. Дараа нь анхны байрлалаас 4 см зөөж зураарай. Ямар хөдөлгөөн хийсэн бэ? Шугам анхны хэлбэрээсээ өөрчлөгдсөн үү? Алхам 2 Координатын хавтгай дээр ABCD дүрс байгуулах (улаан дүрс) Алхам 3 ABCD дүрсийг (1,-2) чиглэлтэй параллель зөөлтөөр хувиргаж A₁B₁C₁D₁ гэж тэмдэглэнэ. (шар дүрс) Алхам 3 A₁B₁C₁D₁ дүрсийг (-2,-6) чиглэлтэй параллель зөөлтөөр хувиргаж A₂B₂C₂D₂ (ягаан дүрс) <ul style="list-style-type: none"> • Дүрс параллель зөөлтөөр тодорхой чиглэлд тодорхой зайд шилждэг 	 <ul style="list-style-type: none"> • Шугамыг анхны байрлалаас нь дараалан өөр зайд зөөхөд шугамны байрлал өөрчлөгдсөн. • Шугамны анхны хэлбэр хэмжээ өөрчлөгдөөгүй. 

<p>Бататгах - 10 минут</p>	<p>Алхам 1 Зураг дээрх W дүрсийн дүр нь T байх параллель зөөлтийн чиглэлийг ол. Алхам 2 Зураг дээрх Q дүрсийн дүр нь W байх параллель зөөлтийн чиглэлийг ол. Алхам 3 Сурах бичгийн 88р хуудасны дасгал 54-56 хийгээрэй.</p>	<p>Алхам 1 (1,-7) Алхам 2 (4,4)</p> 
<p>Үнэлгээ - 5 минут</p>	<p>Алхам 1 Параллель зөөлтөөр дараалан хувиргахад хадгалагдах шинж чанарыг нэрлэх Алхам 3 ABC гурвалжныг (5,0) (0,-7) чиглэлтэй параллель зөөлтөөр хувиргалт хийгээрэй.</p>	
<p>Дүгнэлт - 2 минут</p>	<p>Параллель зөөлт хувиргалтаар дараалсан хувиргалт хийхэд ямар шинж чанарууд ажиглагдаж байсныг нэрлэж, ярилцагсаа.</p>	<ul style="list-style-type: none"> - Параллель зөөлт хувиргалтаар хэрчмийн урт, өнцөг хадгалагддаг - Параллель зөөлтөөр дүрс тодорхой зайд, тодорхой чиглэлий дагуу зөөлт хувиргалт хийнэ.
<p>Гэрийн даалгавар - 2 минут</p>	<ul style="list-style-type: none"> - Сурах бичгийн хуудас 88 дасгал 57-61 хийх - Өөрсдийн мэдэх бодит амьдрал дээрх параллель зөөлтийн жишээг бичиж ирэх 	<ul style="list-style-type: none"> - Дасгал ажиллаж, бодлого бодохдоо зургыг нь зурах - Параллель зөөлтийн жишээ гаргаж ярилцах (Ж.нь: машины шулуун замын хөдөлгөөн)